

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН  
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2019 оны 10 дугаар  
сарын 22-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэлийн нэгдсэн системийг боловсронгуй болгох, иргэдэд туслах сан, сангаас тусламж дэмжлэг үзүүлэх хэлбэрийг тодорхойлох, төрийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын бодлогыг Монгол Улсын иргэн бүрд жигд хүртээмжтэй хүргэх зорилгоор хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Л.Болд гадаадад зорчиж байгаа иргэд дипломат төлөөлөгчийн газраар үйлчлүүлэх, эрхээ хамгаалуулах, төрийн үйлчилгээ авах, сонгууль өгөх, хүүхдийн мөнгө авах, газар өмчлөх, хувьцаа эзэмших зэрэг асуудлуудлыг хуулийн төсөлд хэрхэн зохицуулж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар хилийн чанадад байгаа иргэн нэгдсэн системд бүртгүүлээгүй тохиолдолд үүсэх үүрэг хариуцлага, иргэдэд туслах сантай холбоотой эрхээ хэрхэн эдлэх, иргэн цагаачлах, удаан хугацаагаар гадаадад оршин сууснаар эрх нь зөрчигддөг асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.


Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа,

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Х.НЯМБААТАР**